

БАНКНЫ САЛБАР ДАХЬ ТАТВАРЫН ОРЧИН

Судалгааны хэлтсийн эдийн засагч Г. Ариунхишиг

Зам, эмнэлэг, боловсролын байгууллагууд, нийгмийн аюулгүй байдал зэрэг нийтэд зориулсан бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх, эдийн засаг дахь үр ашиг болон тэгш байдлыг хангах нь засгийн газрын үндсэн үүрэг бөгөөд та бид ч үүнээс өөрт хамаарах ашиг тусыг хүртэж байгаа нь эргэлзээгүй. Харин эдгээр үүргээ гүйцэтгэж, хэрэгжүүлэхийн тулд засгийн газар татвар авах замаар орлогоо бүрдүүлдэг. Бид ч нэгэнт л ашиг тусыг нь хүртдэг учир өөрсдийн халааснаас гарч байгаа эдгээр татварыг төлөх нь зайлшгүй. Харин энэхүү татварын бүтэц нь нийгэмд аль болох бага дарамтыг учруулж, хувийн салбарын ажиллах бололцоог нь олгож, үүнээс үүдсэн ачаалал нь шударга хуваарилагдаж байх зарчмыг баримтлах нь зүйтэй юм гэдэгтэй ихэнх хүмүүс санал нэгтэй байдаг. Хэдийгээр хэлэх амархан ч, энэ зарчмыг бүрэн хангасан татварын системийг бүрдүүлэх нь тун ярвигтай, яг ямар тогтолцоо байх ёстойг нь ч мэдэхэд хэцүү асуудал юм. Жишээ нь, Америкийн эдийн засагч Лафферийн 1974 онд хийсэн судалгаагаар бол татварын түвшинг өсгөх нь татварын орлогыг нэмэгдүүлэх боловч тодорхой цэгээс хойш бууруулах хандлагыг гаргадаг гэсэн дүгнэлт байдаг. Өөрөөр хэлбэл, татварын хэт өндөр түвшин нь хүмүүсийн ажиллах хүсэл эрмэлзлийг бууруулж, татвараас зайлсхийх явдлийг өдөөж, ингэснээр татварын орлого нь буурдаг гэсэн байна.

I. ОРШИЛ

Манай орны хувьд зах зээлийн тогтолцоонд шилжсэнээр үүсэж бий болсон эдийн засгийн өөрчлөлтүүдтэй уялдсан татварын системийг шинэчлэн байгуулах гарцаагүй шаардлагатай тулгарсан бөгөөд 1993 онд анх татварын шинэчлэл хийгдэж, энэхүү шинэчлэлийн хүрээнд татварын төрлүүд, татвар төлөлт, татвар ноогдуулалт зэрэг татвартай холбоотой харилцааг зохицуулах хууль тогтоомжууд батлагдан гарчээ. Монгол улсын татварын ерөнхий бодлого нь татварын дарамтыг нэмэгдүүлэхгүй байх, далд эдийн засгийн үйл ажиллагааг ил болгох зэрэг замаар татварын баазыг өргөтгөх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үндсэн чиглэлтэй юм.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Монголын банкны салбарын татварын орчин, банкуудын татвар төлөлтийн байдал, татвартай холбоотойгоор үүсэн гарч байгаа бэрхшээлүүдийн талаар судалж, дүгнэлт хийх юм. Судалгааны ажилд 2001-2003 оны макро эдийн засаг болон банкны тоон үзүүлэлтүүдийг ашигласан болно.

II. МОНГОЛЫН БАНКНЫ САЛБАР ДАХЬ ТАТВАРЫН ОРЧИН

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн татварын үйл ажиллагааг зохицуулдаг гол хуулиуд нь “Монгол улсын татварын ерөнхий хууль”, “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль” юм. Банк нь ч аж ахуйн нэгж гэдэг утгаараа эдгээр хуулиудыг дагаж мөрддөг. Татварын ерөнхий хууль нь Монгол улсын татварын ерөнхий тогтолцоо, албан татвар, хураамж, төлбөрийн нийтлэг зарчим, татвар төлөгчийн эрх, үүрэг, хариуцлага зэрэгтэй холбогдсон харилцааг зохицуулах үндсэн зорилготой бол Аж ахуйн нэгжийн албан татварын хуулиар аж ахуйн нэгж байгууллагын орлогод албан татвар ноогдуулах, уг албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцаа нь зохицуулагдана.

Аж ахуйн нэгжийн албан татварын хуулийн дагуу татварт ноогдох жилийн орлого нь 100 сая төгрөгөөс доош бол орлогын 15 хувиар, 100 саяас дээш орлоготой аж ахуйн нэгж байгууллага нь 15 сая төгрөг дээр 100 сая төгрөгнөөс дээш орлогын дүнгийн 40 хувиар нэмж татвар төлдөг байсан бол 2003 оны 11 сарын 27-ны өдрийн хуралдаанаар уг хуульд нэмэлт өөрчлөлтийг оруулж, ингэснээр 2004 оны 1 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн аж ахуйн нэгж нь 100 сая төгрөгнөөс дээш орлогын дүнгийнхээ 30 хувиар нэмж татвар төлөх болсон юм. 2003 оны эцсийн байдлаар Монгол улсад нийтдээ 26552 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхэлж байгаагын ердөө 170 аж ахуйн нэгжийн татварт ноогдох орлого нь 100 сая төгрөгөөс дээш байна. Харин Монголын банкны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 17 банк нь бүгд татварын дээд шатлалд багтдаг.

Банкуудын хувьд бусад аж ахуйн нэгжтэй мөн адилаар татварт ноогдох орлогоо тодорхойлох ба харин ялгаатай нь гэвэл зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдалаас хамгаалах санд төвлөрүүлсэн хөрөнгийг татвар ноогдох орлогоос хасч тооцдог байна.

III. БАНКУУДЫН ТАТВАР ТӨЛӨЛТ

2001-2003 онуудад банкны салбарын орлого, зарлагын тайланг хураангуйлсан хэлбэрээр дараахь хүснэгтэд үзүүлбэ.

Хүснэгт 1. Банкны орлого зарлагын нэгдсэн тайлан (тэрбум төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2001	2002	2003
Болзошгүй эрсдлийн зардлын дараах хүүгийн цэвэр орлого	19.25	27.72	38.06
Бусад орлого	17.17	26.68	38.17
Бусад зарлага	20.38	36.58	55.72
Татварын өмнөх орлого	16.03	17.83	20.51
Татвар	6.18	6.83	6.72
Цэвэр ашиг	9.86	10.99	13.79

Хүснэгтээс харахад болзошгүй эрсдэлийн дараахь хүүгийн цэвэр орлого нь 2002 онд 44.0 хувиар өсч байсан бол 2003 онд харьцангуй бага хувиар буюу 37.5 хувиар өссөн байна. Татварын өмнөх орлого 2002 онд 11.2 хувиар, 2003 онд 15 хувиар тус тус өссөн бол харин банкуудын төлсөн татварын хэмжээ 2002 онд 10.5 хувиар өсч, 2003 онд 1.6 хувиар буурчээ. Банкуудын цэвэр ашгийн үзүүлэлтийг харвал энэ нь 2002 онд 11.5 хувиар, 2003 онд 25.5 хувиар өссөн байна. Мөн 2001 ба 2002 онуудад банкууд нь

татварын өмнөх орлогын 38 орчим хувийг татварт төлж байсан бол энэ хэмжээ нь 2003 онд 32 хувь болж буурчээ.

Банкуудыг активийн хэмжээгээр нь том, дунд, жижиг гэж ангилдаг. Ингээд дараахь хүснэгтэд банкуудын татвар төлсөн байдлыг ангилал тус бүрээр нь харууллаа.

Хүснэгт 2. Банкуудын орлого зарлагын тайлан, ангилалаар (тэрбум төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2001			2002			2003		
	Том	Дунд	Жижиг	Том	Дунд	Жижиг	Том	Дунд	Жижиг
Болзошгүй эрсдлийн зардлын дараах хүүгийн цэвэр орлого	10.81	6.35	2.08	10.94	10.78	5.99	17.69	11.94	8.43
Бусад орлого	11.82	3.89	1.33	19.36	5.99	1.19	29.79	4.53	3.72
Бусад зарлага	11.26	6.53	2.59	20.19	11.37	5.02	36.25	10.43	9.04
Татварын өмнөх орлого	11.37	3.71	0.82	10.11	5.40	2.16	11.22	6.04	3.11
Татвар	4.72	1.22	0.24	3.86	2.07	0.89	4.33	1.33	1.06
Цэвэр ашиг	6.65	2.48	0.59	6.25	3.33	1.26	6.90	4.71	2.05

Том банкуудын хувьд татварын өмнөх орлого нь 2002 онд 1.26 тэрбум төгрөг буюу 11 хувиар буурч, 2003 онд нэмэгдсэн ч 2001 оны үзүүлэлтээс доогуур байна. Үүнтэй уялдан татварын хэмжээ 2002 онд 18 хувиар буурсан ба 2003 онд 12 хувиар өссөн нь 2001 оны түвшингээс 0.49 тэрбум буюу 8 хувиар доогуур байгаа юм. Цэвэр ашгийн хувьд 2002 онд 6 хувиар буурч, харин 2003 онд 10.4 хувиар өсчээ. Татварыг татварын өмнөх орлогын хувиар тооцвол, 2001 онд 41 хувь, харин дараа онуудад 38 орчим хувьтай байна.

Дунд хэмжээний банкуудын татварын өмнөх орлого нь 2002 ба 2003 онуудад 45.5 хувь, 11.8 хувиар тус тус өссөн байхад татварын хэмжээ нь 2002 онд 69.7 хувиар нэмэгдсэн бол 2003 онд 36 хувиар буурчээ. Тухайн оны цэвэр ашиг нь 2002 онд 34 хувиар, 2003 онд 41 хувиар тус тус өсчээ. 2001 онд төлсөн татвар нь тухайн оны татварын өмнөх ашгийн 33 хувь, 2002 онд 38 хувь, 2003 онд 21 хувь байв.

Жижиг банкуудын татварын өмнөх орлого нь эдгээр жилүүдэд байнга өсч, өсөлт нь 2002 болон 2003 онд тус тус 2.6 дахин болон 44 хувь байв. Эдгээр банкуудаас төлсөн татварын хэмжээ нь 2002 онд 67 хувиар, 2003 онд 19 хувиар тус тус нэмэгдсэн нь 2001 онд татварын өмнөх орлогын 29 хувь, 2002 онд 41 хувь, 2003 онд 34 хувь байжээ.

Банкны салбарт үйл ажиллагаа явуулж буй банкуудын өсөлтийг ангилал тус бүрээр нь илүү бодитойгоор авч үзье гэвэл бид 2001-2003 онуудад ашигласан ангиллалыг адил байлгах ёстой. Гэвч 2003 онд шинэ ангилал гаргасан, мөн Чингис Хаан ББСБ мөн онд банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсанаар банкны тоо 17 болсоноос 2001, 2002 оны ангилал нь 2003 оны ангилалаас өөр байгаа юм. Иймд илүү бодит харьцуулалтыг хийх үүднээс 2003 оны ангилалд өөрчлөлт оруулж өмнөх онуудыхтай адилтгасан хэлбэрээр дор хүснэгтэд үзүүлэв.

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2001			2002			2003		
	Том	Дунд	Жижиг	Том	Дунд	Жижиг	Том	Дунд	Жижиг
Болзошгүй эрсдлийн зардлын дараах хүүгийн цэвэр орлого	10.81	6.35	2.08	10.94	10.78	5.99	15.14	11.57	8.43
Бусад орлого	11.82	3.89	1.33	19.36	5.99	1.19	25.33	7.92	3.72
Бусад зарлага	11.26	6.53	2.59	20.19	11.37	5.02	30.38	14.83	9.04
Татварын өмнөх орлого	11.37	3.71	0.82	10.11	5.40	2.16	10.08	4.66	3.11
Татвар	4.72	1.22	0.24	3.86	2.07	0.89	4.00	1.20	1.06
Цэвэр ашиг	6.65	2.48	0.59	6.25	3.33	1.26	6.08	3.46	2.05

Хүснэгт 3. Банкуудын орлого зарлагын тайлан, хуучин ангилалаар (тэрбум төгрөгөөр)

Энэхүү хүснэгтээс харахад том банкуудын татвараас өмнөх орлого 2003 онд 0.3 хувиар буурсан үзүүлэлттэй байж, харин татварын хэмжээ нь уг онд 3.6 хувиар өссөн байна. Том банкуудын цэвэр ашиг тус онд 2.7 хувиар буурчээ. Дунд хэмжээний банкуудын хувьд 2003 онд татварын өмнөх орлого нь 13.7 хувиар, татварын хэмжээ 58.0 хувиар тус тус буурсан бол цэвэр ашиг нь 3.9 хувиар өссөн байна. Жижиг банкны ангилалд өөрчлөлт ороогүй тул 2 ба 3 дугаар хүснэгтийн холбогдох үзүүлэлтүүд адил.

IV. ТАТВАР ТӨЛӨХТЭЙ ХОЛБОГДОН ГАРЧ БАЙГАА БЭРХШЭЭЛҮҮД, ДҮГНЭЛТ

Банкууд оны эцэст дараа оныхоо төсвийг татварын газарт хүргүүлснээр дараа жилийнхээ татвар төлөлтийн төлөвлөгөөг гаргуулдаг. Үүнтэй холбоотойгоор үүсдэг хэд хэдэн бэрхшээлүүд байна.

Банкны салбар маань сүүлийн жилүүдэд эрчимтэйгээр хөгжин, өрсөлдөөн маш ихээр нэмэгдсэн. Өмнөх хүснэгтүүдэд нэгтгэсэн тоон үзүүлэлтээс харахад ч, мөн бусад банкны үзүүлэлтээс харахад том банкуудын үйл ажиллагаа тогтворжин, орлого, ашиг нь ерөнхийдөө тогтмолжсон гэж хэлж болно. Харин харьцангуй өндөр өсөлт ажиглагдаж байгаа нь жижиг банкууд юм. Гэвч санхүү, банкны шинэ үйлчилгээг нэвтрүүлэн улам бүр нэмэгдэж буй өрсөлдөөнд өөрийн байр сууриа авч үлдэх, орлогоо өмнөх жилийнхээ түвшинд хадгалах нь ихэнх банкуудын зорилго болж байна. Иймээс бид банкнаас, ялангуяа том банкуудаас төлөх татварын хэмжээг ерөнхийдөө тогтмол байна гэсэн дүгнэлтийг хийж болох юм. Мөн зарим банкуудын хувьд өөрсдийн үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан улирлын хэлбэлзэл ажиглагдах хандлага байдаг. Ямар ч аж ахуйн нэгжийн орлого, зардал, ашгийг тооцохдоо тухайн салбар, үйл ажиллагааны онцлог, өрсөлдөөн зэргийг нарийн авч үзэх нь гарцаагүй. Банкуудын хувьд татварын байгууллагаас урьдчилан төлөвлөгдсөн татварыг, ихэнх тохиолдолд тогтмол хэмжээгээр сар тутам төлж байх нь зарим талаараа учир дутагдалтай юм. Банкуудаас авсан ярилцлагаас харахад татварын байгууллага нь банкуудын бэлтгэж хүргүүлсэн төсвийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан татвараа тогтоодог ба үүнээс үүдэн татварын илүү төлөлттэй гарах нь элбэг байдаг юм байна. Мөн төлөвлөсөн татварыг сар тутам тэнцүү хэмжээгээр төлөх хуваарийг гаргадгаас зарим саруудад төлөх татварын бодит хэмжээ нь

төлөвлөгдсөн хэмжээгээс бага байх явдал ч бас байдаг бөгөөд харин энэ тохиолдолд банкууд ихэвчлэн тухайн сардаа багтаан татвараа нөхөн төлдөг байна. Татварын ерөнхий хуулийн 12.5-д заасны дагуу татвар төлөгч нь (банкууд нь) илүү төлсөн татварыг эргүүлэн авах буюу суутгаж тооцуулах эрхтэй. Гэвч ихэнх тохиолдолд банкуудын аливаа сард төлсөн илүү татварыг эргүүлэн өгдөггүй, дараа сарын татварт ч суутгуулж тооцохгүй, харин илүү төлөлтийг жилийн туршид хуримтлуулж, уг хэмжээгээр нь дараа оны татварт суутган тооцохоор болдог байна. Гэтэл банк, банкны бизнес гэдэг маань өөрөө ямар онцлогтой билээ, мөнгийг ямар нэг хүүгүйгээр, бараг бүтэн жилийн хугацаанд “авдарт” түгжиж орхих нь уг бизнесийн хувьд хэр нийцтэй вэ?

Банкууд сар тутам өөрсдийн тайлан мэдээ, орлого зарлагын тайланг гаргадаг. Иймдээ ч татварыг төлөвлөгөөт хуваарийн дагуу бус харин дараа сарынхаа эхний 15 хоногт багтаан бодит хувиар нь төлөөд явахад нэг их бэрхшээл үүсэхгүй болов уу? Татварын шатлалаас үүдэн ямар нэг асуудал үүслээ гэхэд тухай бүрд нь тооцоод явах мөн л боломжтой асуудал. Хэрвээ ингэж чадвал дээр дурьдсан бүхий л бэрхшээлүүдээс зайлсхийж, банкны үйл ажиллагаагаа дэмжиж чадах юм.

Мөн нэгэнт л банкууд маань бүгд татварын дээд шатлалд багтдаг тул банкуудын хувьд “flat rate” буюу татварын тэгш хэмжээг тогтоох нь зохистой байж болох юм. Бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн хувьд ялгаатай үйл ажиллагаа эрхэлдэг хэд хэдэн охин компанитай байх нь элбэг, тэгээд ч боломжтой зүйл. Манай орны хувьд хөрөнгийн зах зээлийн хөгжил сул, банкаас бусад санхүүгийн үйл ажиллагаа нэг их эрчимжээгүй энэ үед банкны хувьд энэ нь ихээхэн бэрхшээлтэй асуудал юм.

2004 оны 1 сарын 1-нээс эхлэн татварын шинэ түвшин мөрдөгдөж ирсэн. Үүний нөлөөлөл нь банкны салбарын хувьд ямар байгааг үнэлж, банкны салбар дахь татварын ачааллыг тооцох хэрэгтэй. Иймд энэ судалгааг 2004 оны эцсийн үзүүлэлтүүд бэлэн болсны дараа арай дэлгэрүүлж хийх нь зүй болов уу.

Ашигласан ном, хэвлэл

“Татварын ерөнхий хууль”, Монгол улсын хууль, 1992
“Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хууль”, Монгол улсын хууль, 1992
ҮСГ, “Монгол улс зах зээлд” статистикийн эмхтгэл, 2004
Mankiw G., “Principles of Microeconomics”, 1998